БАТЛАВ:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Е.ЗАНГАР

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН САГСАЙ-БУЯНТ-АЛТАЙ СУМ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 01/2025 Өлгий сум

| | |
|---|---|
| 1. Зураг төсөл боловсруулах үндэслэл | Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгын дагуу |
| 2. Байршил | Баян-Өлгий аймгийн Сагсай, Буянт, Алтай сумдын нутаг дэвсгэр |
| 3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар |
| 4. Замын техникийн ангилал, замын зэрэг, хүчин чадал | Авто замын зэрэглэл 2А |
| 5. Замын хучлага | Тооцоогоор |
| 6. Хучилтын хэлбэр | Тооцоогоор |
| 7. Төлөвлөлтийн норм | • “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016<br>• “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНбД 32-02-12;<br>• “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004<br>• “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНбД 22.01.01*/2006 |
| 8. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа | Нарийвчилсан зураг төслийг 2025 оны 2, 3 дугаар улиралд багтаан гүйцэтгэнэ. |
| 9. Зураг төслийн иж бүрдэл | • “Авто зам төсөллөх” ЗЗБНбД 22-004-2016-ийн хавсралт 2-8-ыг баримтлана.<br>• Инженер-геологийн судалгааны ажлын тайлан Карьерын судалгаа /Зам барилгын ажилд хэрэглэх дүүргэгч материал тус бүрээр/<br>• “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНбД |

11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил“ БНбД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах;

- Техник эдийн засгийн үндэслэл
- Инженерийн нарийвчилсан зураг
- Геодезийн хэмжилтийн тайлан
- Хучилтын тооцоо
- Зургийн тайлбар бичиг
- Техникийн шаардлага
- Авто замын трасст орсон шугам сүлжээг шилжүүлэх ажлын зураг төсөл
- Ус зайлуулах байгууламжийн тооцоо
- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ Барилгын ажлын нэгдсэн төсөв
- Ажил гүйцэтгэх аргачлал
- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын ерөнхий дүгнэлт
- Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрлүүд

10. Зураг төслийн байгууллага

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол Улсын хуулийн дагуу сонгон шалгаруулна.

11. Захиалагч байгууллага

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар

12. Онцгой нөхцөл

- Аймаг, сум орон нутгийн ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөртэй уялдуулах, санал авах;
- Хучилтын бүтээцийг ЗТБХБСайдын 2010 оны 313 дугаар тушаалаар батлагдсан “Монгол орны асфальтбетон хучлагтай авто замын хучилтын хийцийн жишиг цомог”-ийг жишиг болгох;
- Суурь үеийг зохист найрлага бүхий материалыг цемент болон түүнтэй адилтгах бэхжүүлэгчээр бэхжүүлэн зориулалтын тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэлийн аргаар хийхээр зураг төсөлд тусгах;
- Замын трассын дагуу 2 км тутамд хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн хэмжилтийг UTM системд хийж гүйцэтгэх;
- Зам, гүүрийн зурваст орсон болон доогуур хөндлөн өнгөрч байгаа инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх,

засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардлыг тооцож зураг төсөлд тусгах;

- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх;
- Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох;
- Хөдөлгөөний аюулгүй байдлын аудитын дүгнэлт гаргах, тэмдэг, тэмдэгжилтийн талаар тухайн холбогдох байгууллагаас санал авах;
- Замын хөдөлгөөнийг зохион байгуулах техник хэрэгсэл, тоноглолыг оновчтой төлөвлөх;
- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах;

13. Зөвшөөрөлцөх байгууллага, албан тушаалтан

Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хэрхэн нийцэж байгаа талаар ажлын зураг, замын трассын байршлыг аймгийн Ерөнхий архитектортай зөвшилцөж батлуулсан байх;

Хянасан:

Баян-Өлгий аймгийн Засаг даргын орлогч К.БАХЫТЖАН

Боловсруулсан:

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн зам, тээвэр, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн Е.ДОСЖАН